



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 11 өдөр

Дугаар А/384

Улаанбаатар хот

Хяналт шалгалт хийх ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 18.1.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны 1, 3, 12, 13, 14 дүгээр байрыг харьяалах "Галт 5" сууц өмчлөгчдийн холбоонд холбогдох асуудлаар иргэдээс ирүүлсэн хүсэлт, санал гомдлын хүрээнд "Галт 5" сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч: Ж.Тамир

Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Г.Хурцбаяр

Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

М.Навчаа

Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Н.Оюунбат

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын

албаны Орон сууц, дэд бүтцийн ашиглалт, сууц өмчлөгчдийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

М.Галбаатар

Монголын Сууц өмчлөгчдийн холбоодын дээд зөвлөлийн Гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)

М.Хоролсүрэн

Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албаны дарга

Н.Сайнболд

1 дүгээр хорооны Засаг дарга

Э.Даваадорж

Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн газрын Цагдаагийн 1 дүгээр хэлтсийн дэд бөгөөд Эрүүгийн цагдаагийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа

1525012258

Ц.Заяат

“Галт 5” сууц өмчлөгчдийн холбооны
Гүйцэтгэх захирал

Ц.Энхболд

“Галт 5” сууц өмчлөгчдийн холбооны
Удирдах зөвлөлийн гишүүн

Нарийн бичгийн

дарга:

Д.Батчимэг


Засаг даргын Тамгын газрын Хотын
стандарт, тохижилт нийтийн аж ахуйн
хэлтсийн мэргэжилтэн

2.Хяналт шалгалтад шаардагдах хөрөнгийг холбогдох зардлаас гаргахыг
Засаг даргын Тамгын газар (Ж.Тамир)-т зөвшөөрсүгэй.

3.“Галт 5” сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаанд хийх хяналт
шалгалтын ажлыг зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Ажлын хэсэг
(Ж.Тамир)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч
(Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ